



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 03 -ны өдөр

Дугаар А/23

Эрдэнэт

Нийгмийн халамж нэн шаардлагтай бүлгийн эхчүүдэд  
зориулсан нэмэлт амин дэм худалдан авах  
хуваарилах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дах заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн ээлжит хуралдааны 11/04 дүгээр тогтоол, Орхон аймгийн Засаг даргын 2023 оны "Нэмэлт аминдэмээр хангахад дэмжлэг үзүүлэх тухай" А/195 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн эхчүүдэд зориулсан нэмэлт аминдэмийг олгож, тайлан мэдээг нэгтгэх, олгох журмыг нэгдүгээр, аминдэмийн зарцуулалтад хяналт тавих багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, аминдэм олгосон эхчүүдийн бүртгэлийн хуудсыг гуравдугаар, нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдэд түгээх амин дэмийн хуваарилалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн эхчүүдийг аминдэмжүүлэлтэд хамруулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Хоол тэжээл хүнсний аюулгүй байдал, амны хөндийн эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн (П.Баярмаа)-д даалгасугай.
3. Аминдэмжүүлэлтэд шаардагдах 10.000.000 (арван сая) төгрөгийг "Нэмэлт дансны эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардал"-с гаргахыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн Эрүүл Мэндийн Төвийн Эрүүл мэндийн боловсрол сургалт сурталчилгаа олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (А.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны  
07 дүгээр сарын 03-ны өдрийн  
4/23 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдийг аминдэмжүүлэлтэд хамруулах журам

Энэхүү журам нь Сум өрхийн эрүүл мэндийн төв, БОЭТ-ийн Өртөмтгий бүлгийн жирэмсэн эхийг хянах кабинетын хяналтад бүртгэгдсэн, нийгмийн халамж нэн шаардлагатай, бүлгийн эхчүүдийг нэмэлт аминдэмээр үнэ төлбөргүй хангах харилцааг зохицуулна.

1. СӨЭМТ, ӨБЖЭХК-ийн эмч нар нь зорилтот бүлгийн нэмэлт аминдэмд хамрагдах заалттай эхчүүдийн судалгаа, оношийн үндэслэлийг гаргаж, цус багадалттай эхчүүдийн аминдэм уухын өмнөх цусны дэлгэрэнгүй шинжилгээтэй хавсарган эрүүл мэндийн газрын хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал, амны хөндийн эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн (ХТХАБАХЭХАХМ)-д улирал бүр өгч, нярваас хүлээн авна.
2. Орхон Монос ЭХНБ нь аминдэмийн хуваарь гарснаас хойш 7 хоногт багтааж, ЭМГ-ын няравт аминдэмийг хүлээлгэн өгч, баримтжуулсан хуудас, Е-баримтыг Эрүүл мэндийн газрын ЭБХЧАБХМ мэргэжилтэн (О.Анхбаяр)-аар шалгуулж, Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтанд хүлээлгэн өгнө.
3. Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан ЭХНБ-аас ирүүлсэн нэхэмжлэл, зарлагын баримтыг үндэслэн мөнгөн гүйлгээг хийнэ.
4. СӨЭМТ-ийн эмч нар өөрийн харьяаллын нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдээс нийгэм биологийн болон эх барихын ужиг дутагдалтай эхчүүдийг сонгон аминдэмжүүлэлтэд хамруулна. Үүнд:
  - Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн ээжүүд, оюутан, хөгжлийн бэрхшээлтэй жирэмсэн ээжүүд, хоол тэжээлийн архаг дутагдалтай жирэмсэн болон хөхүүл ээжүүд (БЖИ 18,5-аас бага), цус багадалттай жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд олгоно.
  - 15-аас өмнөх насанд жирэмсэлсэн, хэт намхан 140 см-ээс бага өндөртэй, ихэр жирэмсэн, хэт ойрхон жирэмсэлсэн, ихэсийн дутмагшил, ургийн өсөлтийн саатал оношлогдсон жирэмсэн эхчүүдэд олгоно.
5. Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн эхчүүдэд бэлдмэлийг олгоходоо 1 эхэд 30 ширхэгээр олгож 30 өдрийн туршид уулгана. Шаардлагатай тохиолдолд үргэлжлүүлэн 30 хоног олгож болно.

6. СӨЭМТ, ӨБЖЭХК-ийн эмч нар зорилтот бүлгийн эхийг сонгож, оношийн үндэслэлийг гаргаж, арга зүйч сувилагчид илгээж, арга зүйч нар эмийг түгээж, цус багадалттай эхийн шинжилгээг хавсаргаж, баримтжуулах ажлыг хариуцна.
7. Өрхийн эрүүл мэндийн төвүүд нэмэлт аминдэмийг зааврын хамт эхчүүдэд олгож гарын үсэг зуруулж баталгаажуулсан бүртгэлийн хуудсыг дараа улирлын 1 дэх сард багтаан ЭМГ-ын ХТХАБАХЭАХМэргэжилтэнд ирүүлнэ.
8. СӨЭМТ, ӨБЖЭХК-ийн эмч нар эхэд аминдэм олгосноос 30 хоногийн дараа давтан шинжилгээнд хамруулж, эмчилгээний үр дүнг тооцож, арга зүйч сувилагч нэгдсэн тандалтын хуудаст тэмдэглэн мэдээг ЭМГ-ын ХТХАБАХЭАХМэргэжилтэнд ирүүлнэ.
9. Аминдэмийн зарцуулалтад хяналт хийх баг нь хагас жил тутамд СӨЭМТ, ЖӨБЭХК-аар зорилтот бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхэд олгосон аминдэмийн чанар хүртээмж, хэрэглээний үр дүнг үнэлэх хяналтыг зохион байгуулж, удирдлагад тайлагнана.
10. Амин дэмийг зориулалтын дагуу зарцуулаагүй тохиолдолд СӨЭМТ-үүдэд нөхөн төлбөр ноогдуулж хариуцлага тооцно.

Журам боловсруулсан: ХТХАБААХЭАХМ *П.Баярмаа* П.Баярмаа





Нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдэд зориулсан нэмэлт аминдэмийн зарцуулалтад хяналт тавих багийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч : Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал, амны хөндийн эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

1. Сум, өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон ахмад настны асуудал хариуцсан мэргэжилтэн
2. Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн
3. Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн



Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны  
 04 дүгээр сарын 03-ны өдрийн  
 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

НИЙГМИЙН ХАЛАМЖ НЭН ШААРДЛАГАТАЙ ЭХЧҮҮДЭД АМИНДЭМ ОЛГОСОН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

№	Овог, нэр	Регис-терийн дугаар	Холбоо барих утас	Хариуцсан эмчийн нэр	Үндсэн онош Загвар / DS:Gr X XX-XX нед	Өртөмтгий байдал				Гемоглобины хэмжээ		гөвдөгний дав $^{\circ}\text{C}$	Төрийн аминдэмийн тоо	Аминдэм олгосон хүний гарын үсэг	Аминдэм хүлээн авсан $02.10.0001$ /Луя
						Цус багадалт	Эх барихын ужиг датгалтай	Экстрагегитал өвчтэй	НХХШ бүлэг	Аминдэм хэрэглэхийн өмнө	Аминдэм хэрэглэсний дараа				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16

Бүртгэл хөтөлсөн: Сувилагч  
 Хянасан: Арга зүйч

гарын үсэг / нэр /  
 гарын үсэг / нэр /



Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны  
 04... дүгээр сарын 23-ны өдрийн  
 №... дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

Нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдэд түгээх аминдэмийн хуваарилалт

2023 оны 03 сарын 31

№	Өрхийн эмнэлгийн нэр	Нийт жирэмсэн эхийн тоо	Нийт жирэмсэн эхийн тоо	II-р улирал			III-р улирал			IV-р улирал			Нийт аминдэмд хамрагдах эхийн тоо	Эм түгээсэн он сар өдөр	Хүлээн авсан хүний нэр
				аминдэм олгох эхийн тоо	1 эхэд олгох эмийн тоо	Нийт эмийн дүн	аминдэм олгох эхийн тоо	1 эхэд олгох эмийн тоо	Нийт эмийн дүн	аминдэм олгох эхийн тоо	1 эхэд олгох эмийн тоо	Нийт эмийн дүн			
1	Үйлсбадрах	90	85	28	30	840	20	30	600	20	30	600	68		
2	Нийцэл	136	82	28	30	840	25	30	750	25	30	750	78		
3	Мөнхийн гэгээ	69	78	23	30	690	20	30	600	20	30	600	63		
4	Энхжих мандирваа	133	164	30	30	900	30	30	900	25	30	750	85		
5	Анхны-Оч	220	103	35	30	1050	35	30	1050	30	30	900	100		
6	Мэндцэцэн	177	201	35	30	1050	35	30	1050	30	30	900	100		
7	Учралтбаяр	164	64	28	30	840	25	30	750	25	30	750	78		
8	Мөнхсүндрэл	89	92	28	30	840	20	30	600	20	30	600	68		
9	Жаргалант сум	22	14	10	30	300	10	30	300	10	30	300	30		
10	Эрүүл мэндийн газар - нөөц			6	30	180	6	30	180	7	30	210	19		
Дүн		1100	883	251		7530	226		6780	212		6360	689		

Хуваарийг хийсэн: *Т.Баярмаа*  
 Аминдэмийг түгээсэн:

ХТХАБААХЭХАХМ П.Баярмаа  
 Нярав Б.Алтанзагас